



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/321

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/291 дүгээр захирамж, Багануур дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/136 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Их булаг интернэшнл” ХХК-тай байгуулсан “Багануур дүүргийн нийгмийн салбарын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” НХААГ/20190543702 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Багануур дүүргийн нийгмийн салбарын байгууллагуудад нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /М.Энхболд/-т даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 09. дүгээр сарын 1.9. өдрийн 1/321 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Алтангэрэл	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн сургалт, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Б.Мөнхчимэг	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Я.Одгэрэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Батаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн